



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ТӨВ УТУГ-ЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/14/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261628 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитор: Г.Мөнхчимэг
Утас: 260512 Цахим хаяг: munkhchimegg@aaudit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Баян суварга аудит"
ХХК-ийн захирал С.Должинсүрэн
Утас: 99126723 Цахим хаяг: doljinsuren9@yahoo.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа	17
4.1 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ОЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ТӨВ
УТУГ-ЫН ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.ЦАГААНХҮҮ
ТАНАА

2022.02.25 № 07/373
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ойн судалгаа, хөгжлийн төв УТУГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ойн судалгаа, хөгжлийн төв УТУГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,026,650,826.52	579,576,328.01
33	АВЛАГА	12,810,340.42	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	3,587,059.42	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		
335	Бусад авлага	9,223,281.00	-
3351	Байгууллагаас авах авлага	9,223,281.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	1,013,840,486.10	579,576,328.01
351	Түүхий эд материал	21,022,450.00	57,886,550.00
35110	Тусгай зориулалттай материал	21,022,450.00	57,886,550.00
354	Хангамжийн материал	992,818,036.10	521,689,778.01
35410	Бичиг хэргийн материал	356,000.00	70,380.00
35470	Бусад хангамжийн материал	992,462,036.10	521,619,398.01
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,134,605,726.72	8,837,887,859.30
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,134,605,726.72	8,837,887,859.30
392	Биет хөрөнгө	2,962,757,726.78	2,668,528,192.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	699,199,430.00	699,670,430.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(124,718,466.48)	(138,996,399.72)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,877,908,377.00	2,024,208,377.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(769,045,642.34)	(1,193,321,972.61)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,219,772,700.90	1,429,200,924.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	(472,193,137.15)	(697,651,036.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,245,336.80	58,034,676.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,909,723.23)	(32,962,711.22)
39214	Бусад үндсэн хөрөнгө	618,967,068.50	637,587,468.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	(103,468,217.22)	(117,241,564.01)
393	Биет бус хөрөнгө	6,171,847,999.94	6,169,359,666.58
39301	Программ хангамж	14,247,000.00	18,472,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(11,000,000.06)	(17,713,333.42)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,168,601,000.00	6,168,601,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,161,256,553.24	9,417,464,187.31
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
413	Өглөг		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,161,256,553.24	9,417,464,187.31
51	Засгийн газрын хувь оролцоо	10,161,256,553.24	9,417,464,187.31
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,696,476,268.14	6,696,476,268.14
51101	Өмч: - төрийн	6,696,476,268.14	6,696,476,268.14
512	Хуримтлагдсан үр дүн	3,389,953,031.91	2,646,160,665.98
51210	Өмнөх үеийн үр дүн	2,197,572,409.63	3,389,953,031.91
51220	Тайлант үеийн үр дүн	1,192,380,622.28	(743,792,365.93)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	74,827,253.19	74,827,253.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,161,256,553.24	9,417,464,187.31

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,181,087,864.50	2,850,149,247.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,448,871,808.50	126,273,727.13
120	Нийтлэг татварын бус орлого	1,448,871,808.50	126,273,727.13
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,448,871,808.50	126,273,727.13
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,376,200.00	140,200.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,441,495,608.50	126,133,527.13
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,732,216,056.00	2,723,875,520.42
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,525,088,700.00	2,512,288,461.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,525,088,700.00	2,512,288,461.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	207,127,356.00	211,587,059.42
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	197,227,356.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,900,000.00	208,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	3,587,059.42
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,988,707,242.22	3,203,858,850.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,988,707,242.22	3,203,858,850.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,349,563,554.85	3,086,612,580.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	556,100,737.16	179,155,114.58
210101	Үндсэн цалин	484,269,808.99	112,846,690.32
210102	Нэмэгдэл цалин	65,960,077.12	54,953,424.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,870,851.05	11,355,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,933,308.23	25,647,919.66
210201	Тэтгэврийн даатгал	31,672,485.23	17,721,839.20
210202	Тэтгэмжийн даатгал	3,798,370.00	1,981,520.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,038,695.00	1,585,216.15
210204	Ажилгүйдлийн даатгал	749,743.00	396,304.08
210205	Эрүүл мэндийн даатгал	7,674,015.00	3,963,040.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,944,441.00	22,558,418.00
210301	Гэрэл, цахилгаан	15,578,261.00	15,927,418.00
210302	Түлш, халаалт	7,366,180.00	6,631,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	189,228,894.07	175,392,079.76
210401	Бичиг хэрэг	4,868,160.00	5,774,240.00
210402	Тээвэр, шатахуун	164,710,623.00	24,145,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,265,011.07	3,084,194.87
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,385,100.00	2,633,470.00
210408	Бараа материал акталсны зардал	-	139,755,174.89
2105	Норматив зардал	2,850,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,850,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,420,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,420,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	102,378,000.00	24,506,000.00
210702	Дотоод албан томилолт	102,378,000.00	24,506,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,468,910,093.00	2,200,248,995.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,459,945,364.00	2,195,799,900.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		3,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,958,016.00	758,970.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,015,913.00	624,125.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,990,800.00	66,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	516,035,926.64	459,104,053.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	92,855,725.25	36,252,659.03
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	423,180,201.39	422,851,394.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,905,842.12	117,246,269.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,473,600.00	33,979,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	420,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,053,600.00	33,979,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,432,242.12	83,266,669.50
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,432,242.12	83,266,669.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,192,380,622.28	(353,709,602.73)
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		390,082,763.20
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		
КТ(225005)	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	390,082,763.20
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)		(390,082,763.20)
	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	1,192,380,622.28	(743,792,365.93)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,696,476,268.14	75,494,386.19	2,196,905,276.63	8,968,875,930.96
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			667,133.00	667,133.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,696,476,268.14	75,494,386.19	2,197,572,409.63	8,969,543,063.96
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт		(667,133.00)		(667,133.00)
Тайлант үеийн үр дүн			1,192,380,622.28	1,192,380,622.28
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,696,476,268.14	74,827,253.19	3,389,953,031.91	10,161,256,553.24
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,696,476,268.14	74,827,253.19	3,389,953,031.91	10,161,256,553.24
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
Тайлант үеийн үр дүн			(743,792,365.93)	(743,792,365.93)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,696,476,268.14	74,827,253.19	2,646,160,665.98	9,417,464,187.31

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>3,743,592,256.00</u>	<u>2,727,900,520.42</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,376,200.00	4,025,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,376,200.00	4,025,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,376,200.00	140,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,376,200.00	140,200.00
120009	Бусад орлого		3,884,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,732,216,056.00	2,723,875,520.42
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,525,088,700.00	2,512,288,461.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,525,088,700.00	2,512,288,461.00
131005	Хөрөнгийн санхүүжилт		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	207,127,356.00	211,587,059.42
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	197,227,356.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,900,000.00	208,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3,587,059.42
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,285,344,842.00</u>	<u>2,727,900,520.42</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>2,285,344,842.00</u>	<u>2,727,900,520.42</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>2,200,271,940.46</u>	<u>2,610,654,250.92</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	310,643,809.05	179,155,114.19
210101	Үндсэн цалин	209,458,421.51	112,846,689.93
210102	Нэмэгдэл	67,272,635.00	54,953,424.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,912,752.54	11,355,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,907,680.74	25,647,919.66
210201	Тэтгэврийн даатгал	32,658,032.74	17,721,839.20
210202	Тэтгэмжийн даатгал	3,036,005.00	1,981,520.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,409,829.00	1,585,216.15
210204	Ажилгүйдлийн даатгал	602,483.00	396,304.08
210205	Эрүүл мэндийн даатгал	6,201,331.00	3,963,040.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,891,180.00	17,209,937.00
210301	Гэрэл, цахилгаан	16,525,000.00	10,578,937.00
210302	Түлш, халаалт	7,366,180.00	6,631,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	59,355,531.07	33,771,284.87
210401	Бичиг хэрэг	4,554,920.00	3,908,620.00
210402	Тээвэр, шатахуун	49,838,100.00	24,145,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,542,511.07	3,084,197.87
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,420,000.00	2,633,470
2105	Норматив зардал	2,850,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,850,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,420,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,420,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	-	24,506,000.00
210702	Дотоод албан томилолт	-	24,506,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,750,120,239.60	2,312,374,995.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,749,507,826.60	2,307,925,900.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	3,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	758,970.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	612,413.00	624,125.00

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		66,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,083,500.00	17,989,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,083,500.00	17,989,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	85,072,901.54	117,246,269.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,053,600.00	33,979,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,053,600.00	33,979,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	50,019,301.54	83,266,669.50
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,432,242.12	83,266,669.50
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэх	3,587,059.42	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,458,247,414.00</u>	=
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,458,247,414.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,458,247,414.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	1,458,247,414.00	-
222001	Тоног төхөөрөмж		
223001	Бусад хөрөнгө	1,458,247,414.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(1,458,247,414.00)</u>	=
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,735,028,800.00	2,516,313,461.00	218,715,339.00	92.0
УРСГАЛ ЗАРДАЛ	2,735,028,800.00	2,516,313,461.00	218,715,339.00	92.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,701,049,200.00	2,399,067,191.92	301,982,008.08	88.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	199,043,100.00	178,538,055.19	20,505,044.81	89.7
Үндсэн цалин	117,808,600.00	112,229,630.93	5,578,969.07	95.3
Нэмэгдэл	67,084,500.00	54,953,424.26	12,131,075.74	81.3
Унаа хоолны хөнгөлөлт	14,150,000.00	11,355,000.00	2,795,000	80.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,870,800.00	25,647,919.66	1,222,880.34	95.4
Тэтгэврийн даатгал	18,909,100.00	17,721,839.20	1,187,260.80	93.7
Тэтгэмжийн даатгал	1,990,400.00	1,981,520.18	8,879.82	99.6
ҮОМШӨ-ний даатгал	1,592,300.00	1,585,216.15	7,083.85	99.6
Ажилгүйдлийн даатгал	398,100.00	396,304.08	1,795.92	99.5
Эрүүл мэндийн даатгал	3,980,900.00	3,963,040.05	17,859.95	99.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,354,600.00	17,209,937.00	7,144,663.00	70.7
Гэрэл, цахилгаан	17,723,600.00	10,578,937.00	7,144,663.00	59.7
Түлш, халаалт	6,631,000.00	6,631,000.00	0.00	100.0
Хангамж, бараа материалын зардал	46,008,800.00	33,771,284.87	12,237,515.13	73.4
Бичиг хэрэг	4,172,500.00	3,908,620.00	263,880.00	93.7
Тээвэр, шатахуун	35,605,800.00	24,145,000.00	11,460,800.00	67.8
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,518,000.00	3,084,194.87	433,805.13	87.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,712,500.00	2,633,470.00	79,030.00	97.1
Норматив зардал	2,851,200.00		2,851,200.00	
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,851,200.00		2,851,200.00	
Эд хогшил, урсгал засварын зардал	1,425,600.00		1,425,600.00	
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,425,600.00		1,425,600.00	
Томилолт, зочны зардал	40,579,100.00	24,506,000.00	16,073,100.00	60.4
Дотоод албан томилолт	40,579,100.00	24,506,000.00	16,073,100.00	60.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,340,766,700.00	2,101,404,995.20	239,361,704.80	89.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,339,182,700.00	2,096,955,900.20	242,226,799.80	89.6
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	3,000,000.00		100.0
Даатгалын үйлчилгээ	792,000.00	758,970.00	33,030.00	95.8
Тээврийн хэрэгслийн татвар	633,600.00	624,125.00	9,475.00	98.5
Тээврийн хэрэгслийн оношилгоо	158,400.00	66,000.00	92,400.00	41.7
Бараа үйлчилгээний бусад зардал	19,149,300.00	17,989,000.00	1,160,300.00	93.9
Бараа үйлчилгээний бусад зардал	19,149,300.00	17,989,000.00	1,160,300.00	93.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,979,600.00	33,979,600.00		100.0

Бусад урсгал шилжүүлэг	33,979,600.00	33,979,600.00		100.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	33,979,600.00	33,979,600.00		100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,735,028,800.00	2,516,313,461.00	218,715,339.00	92.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,735,028,800.00	2,512,288,461.00	222,740,339.00	91.9
Улсын төсвөөс санхүүжих	2,735,028,800.00	2,512,288,461.00	222,740,339.00	91.9
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС				
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих				
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4,025,000.00	(4,025,000.00)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
БАЙГУУЛЛАГЫН ТОО				
Төсвийн байгууллага	1	1		
АЖИЛЛАГСДЫН ТОО	12	12		100.0
Удирдах ажилтан	1	1		100.0
Гүйцэтгэх ажилтан	11	11		100.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ойн судалгаа, хөгжлийн төв УТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн бүртгэл, эзэмшил, шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян суварга Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Юра, аудиторын туслах Ч.Эрдэнэчимэг нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Мөнхзул, захирал С.Должинсүрэн нар тус тус хэрэгжүүлсэн.

Ойн судалгаа, хөгжлийн төв УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Ойн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулахад шаардлагатай мэдээллийг шинжлэх ухаан, техникийн дэвшилтэд арга технологид тулгуурлан ойн тогтвортой хөгжлийг хангахуйцаар боловсруулж бүрдүүлэх, ногоон хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд өөрийн чиг үүргийн дагуу оролцоход оршино.

Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мод, сөөгийн үрийн дээжид шинжилгээ хийх, ойн шилмэл үрийн нөөц бүрдүүлэх, хадгалах, худалдан борлуулах;
- Монгол оронд ургадаг модлог ургамлын цуглуулгын цэцэрлэгт хүрээлэнгийн үйл ажиллагаа эрхлэх;
- Ойн тооллого, ойн зохион байгуулалтын ажлын тайланг нэгтгэн боловсруулах, дүн шинжилгээ хийх, сэдэвчилсэн зураг боловсруулах;
- Ойжуулалтын ажлын зураг төсөл хийх, таримал ойг улсын ойн санд хүлээн авах эсэх талаар дүгнэлт гаргах;
- Хууль бус мод бэлтгэл, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа бусад арга хэмжээг зохион байгуулах, хяналт тавих;
- Ойн хөнөөлт шавьж, өвчний голомтын судалгаа хийж, дүгнэлт гаргах;
- Ойн тооллого, ой зохион байгуулалт, хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх ажлыг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих;
- Ойгоос мод бэлтгэх талбай тусгаарлах болон ойн арчилгаа, цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах, сургалт, хяналт хийх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;

- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаал "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам";
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Ой судалгаа, хөгжлийн төв УТҮГ-ын захирлын 2021 оны А/09 дугаар тушаалаар "Дотоод аудитын үйл ажиллагааны дүрэм", А/63 дугаар тушаалаар Дотоод хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах албан тушаалтныг томилж, тайлант онд 14 асуудал төлөвлөн ажилласан боловч байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, тооцоо, зарцуулалт, шилэн дансны мэдээллийн хөтлөлтийн хэрэгжилтэд дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ойн судалгаа, хөгжлийн төв УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "бага" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 3,988,707.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 79,774.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 63,819.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ойн судалгаа, хөгжлийн төв УТҮГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 743,802.3 мянган төгрөгөөр буюу 7.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	12,820.3	-	(12,820.3)
Урьдчилгаа (урьдчилж гарсан зардал)	-	-	-
Бараа материал	1,013,830.5	579,576.3	(434,254.2)
Үндсэн хөрөнгө	9,134,605.7	8,837,887.9	(296,717.8)
Нийт хөрөнгө	10,161,256.5	9,417,464.2	(743.802.3)
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	10,161,256.5	9,417,464.2	(743,802.3)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө/ өмчийн дүн	10,161,256.5	9,417,464.2	(743.802.3)

Авлага дансны үлдэгдэл 12,820.3 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлагыг барагдуулснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 579,576.3 мянган төгрөг болж 434,254.2 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын болон хангамжийн материалаас 390,082.8 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгө дансанд шилжүүлсэн, 139,755.2 төгрөгийн бараа материал акталж данснаас хассанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,837,887.9 мянган төгрөг болж 296,717.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардалд 422,851.4 мянган төгрөгийг бүртгэж, 2021 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу бараа материалын данснаас үндсэн хөрөнгийн дансанд нийт 390,082.8 мянган төгрөгийн хөрөнгийг залруулан бүртгэж, эдгээр хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн 276,700.4 мянган төгрөгийг нэмж бүртгэсэн, ТӨБЗГ-ын 2021 оны 559 дүгээр тогтоолоор БОАЖЯ-наас 12,751.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг балансаас балансад шилжүүлж авснаас шалтгаалжээ.

Ойн судалгаа, хөгжлийн төв УТҮГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,330,938.7 мянган төгрөгөөр буюу 55.0 хувиар буурсан нь төсөвт байгууллагын өөрийн орлого 1,322,598.1 мянган төгрөгөөр, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 1,012,800.2 мянган төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 784,848.3 мянган төгрөгөөр буюу 19.7 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа, ажил үйлчилгээний зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, урсгал шилжүүлгийн зардлууд байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2021 оны төсвийн төслийг 3,316,351.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 581,322.3 мянган төгрөгөөр бууруулж 2,735,028.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийг санхүүжүүлэхээр 2,479,288.2 мянган төгрөг, үйл ажиллагааны урсгал зардалд 255,751.1 мянган төгрөгийг тус тус улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,512,288.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 4,025.0 мянган төгрөг, нийт 2,516,313.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,433,046.8 мянган төгрөгийг зарцуулж 83,266.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,516,313.5 мянган төгрөг буюу 92.0 хувьтай байгаа нь цалин хөлсний зардал 20,505.0 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 1,222.9 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 12,237.5 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардал 16,073.1 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 239,361.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 1,160.3 мянган төгрөгөөр тус тус дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Ойн судалгаа, хөгжлийн төв УТҮГ-ын 2021 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.6 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Тайлант онд БОАЖЯ-ны санхүүжилтээр Ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд ойн зохион байгуулалт, доройтсон ойн цэвэрлэгээ хийж ургалтад туслах, хөнөөлт шавжтай тэмцэх зэрэг хөтөлбөр хэрэгжүүлэхээр 2,479,288.2 мянган төгрөг төлөвлөж 60 ААНБ-тай гэрээ байгуулж ажилласнаас гүйцэтгэлээр 2 ажил хийгдээгүй буюу нийт 2,175,345.9 мянган төгрөгийн биелэлттэй гарч, хөтөлбөрийг 87.7 хувиар хэрэгжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Ойн судалгаа, хөгжлийн төв УТҮГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй боловч байгууллагын эзэмшилд байхгүй, орон нутгийн ойн ангиудад ашиглагдаж байгаа 7 нэр төрлийн 326,376.9 мянган төгрөгийн трактор, автомашин, мотоцикл зэрэг авто тээврийн хэрэгслүүдийг хэнд хариуцуулсан нь тодорхойгүй, эзэмшигчид нь хүлээлцсэн акт баримт байхгүйгээр ашиглуулж байна. Мөн 8 нэрийн 31,899.5 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж хаана, хэнд ашиглагдаж байгаа нь тодорхойгүйгээр үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж байгаа нь төрийн өмчийн хөрөнгийг зүй бусаар зарцуулах боломж олгож хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт сул байгаа харуулж байна.

Цаашид дээрх асуудалд анхаарч хөрөнгийг зохих журмын дагуу бүртгэлжүүлэх, ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах нь зүйтэй гэж аудитаар зөвлөмж өгсөн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу дараах байдлаар нийцлийн аудитын асуудлыг тайланд тусгасан болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 9 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-ын 2021 онд нийт 8,724.7 сая төгрөгийн 292 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2,366.7 сая төгрөгийн санхүүжилтийн орлогын гүйлгээний 37 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

БОАЖЯ-ны санхүүжилтээр Ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг БОАЖС-ын 2021 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн А/78 дугаар, 2021 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн А221 дүгээр тушаалуудаар хэрэгжүүлэх арга хэмжээ тус бүрээр баталсныг 2021 оны А/346 дугаар тушаалаар өөрчлөлт оруулж Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд тоног төхөөрөмжөөр хангах зорилгоор нийт 59,809.2 мянган төгрөгийн үнэ бүхий 27 ширхэг зөөврийн компьютер бэлтгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн Газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дүгээр заалтыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дээрх хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 707,326.7 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илрүүлснээс 424,672.7 мянган төгрөгийн 1 алдааг залруулах, 282,654.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

Өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад 424,672.7 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, бусад 4 асуудлыг хэрэгжүүлж, 1 асуудлын 1,766.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 92,638.9 мянган төгрөгийн зөрчил арилгах тухай 2 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж, 15,333.3 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	92,638.9	2	92,638.9	-	-	-

Зөвлөмж	2	15,333.3	2	15,333.3	-	-	-
Нийт дүн	4	107,972.2	4	107,972.2			

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

БОАЖС-ын 2021 оны А/346 дугаар тушаалаар баталсан “Ойжуулалт хөтөлбөр”, тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг тоног төхөөрөмжөөр хангах санхүүжилтээр авсан 59,809.2 мянган төгрөгийн 27 нөтбүүкийн бүртгэл тайлагналыг авч үзэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 784,715.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 424,672.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 360,042.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Хангамжийн материалд бүртгэлтэй 424,672.7 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж залруулсан.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Төслийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ашиглалтгүй хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус төвийн захирлын 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/016 тушаалаар бараа материалын дансанд бүртгэлтэй 6 нэрийн 14,274.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хасахаар шийдвэрлэсэн байна. Гэвч 2021 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор 1,766.0 мянган төгрөгийн DELL зөөврийн компьютер биетээр байхгүй болох нь тогтоогдсон ба байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр гаргаж эзэн холбогдогчид нь авлага үүсгэж бүртгээгүй байна.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдлийг зөрчиж, НББТХуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгө хариуцаж байсан эзэн холбогдогчийг тогтоож, хөрөнгийг авлагаар бүртгэж байгууллагыг хохиролгүй болгох арга хэмжээ авах.

Хөрөнгийн эзэмшилтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тус төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2016 оноос орон нутгийн Ойн ангиудад ашиглагдаж байгаа 8 нэр төрлийн 326,376.9 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг хүлээлцсэн акт, техникийн баримт бичиг, байхгүй, эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл хөтлөөгүй байна.

Түүнчлэн 8 нэр төрлийн 31,899.5 мянган төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг нэг бүрчлэн тоолж эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл хөтлөөгүй байна.

Энэ нь ТБОНӨТХуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.1-д “үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодохын дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх, техник, технологийн баримт бичгийг гүйцэд бүрдүүлсэн байх”, НББТХуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “ажилтан, албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл” НХМаягт БМ-10-ыг бүрэн хөтлөх.

Цаашид төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, бүртгэл, тайлан тооцоонд тавих дотоод хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
							Залруулга		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар														
1	Ойн судалгаа, хөгжлийн төв УТҮГ	АХГ-2022/14/Н А-СТА-ТШЗ	Нийт 424,672.7 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийг хангамжийн материалын дансанд бүртгэсэн.	Аудитаар үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж залруулсан.	1	424,672.7	1	424,672.7						
2	Ойн судалгаа, хөгжлийн төв УТҮГ	АХГ-2022/14/Н А-СТА-ТШЗ	2021 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор 1,766.0 мянган төгрөгийн DELL зөөврийн компьютер биетээр байхгүй ба байгууллагын ӨХБЗ-ийн шийдвэр гаргаж, эзэн холбогдогчид нь авлага үүсгэж бүртгээгүй.	Хөрөнгө хариуцаж байсан эзэн холбогдогчийг тогтоож, хөрөнгийг авлагаар бүртгэж байгууллагыг хохиролгүй болгох.	1	1,766.0							1	1,766.0
3	Ойн судалгаа, хөгжлийн төв УТҮГ	АХГ-2022/14/Н А-СТА-ТШЗ	Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, 2016 оноос орон нутгийн Ойн ангиудад ашиглагдаж байгаа 8 нэр төрлийн 326,376.9 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг хүлээлцсэн акт, техникийн баримт бичиг байхгүй, эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл хөтлөөгүй байна. Түүнчлэн 8 нэр төрлийн 31,899.5 мянган төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг нэг бүрчлэн тоолж эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл хөтлөөгүй.	Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “ажилтан албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл” НХМаягт БМ-10-ыг бүрэн хөтлөх. Цаашид төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, бүртгэл, тайлан тооцоонд тавих дотоод хяналтыг сайжруулах.	1	358,276.4							1	358,276.4
Дүн					3	787,715.1	1	427,672.7					2	360,042.4
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал														

Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1	Ойн судалгаа, хөгжлийн төв УТҮГ	АХГ-2022/14/Н А-СТА-ТХН	Тус төв тайлант онд 8,724.7 сая төгрөгийн 202 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2,366.7 сая төгрөгийн санхүүжилтийн орлогын гүйлгээний 37 мэдээллийг байршуулаагүй байна.	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.	1						1			
	Ойн судалгаа, хөгжлийн төв УТҮГ	АХГ-2022/14/Н А-СТА-ТХН	БОАЖЯ-ны санхүүжилтээр Ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг БОАЖС-ын 2021 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн А/78 дугаар, 2021 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн А221 дүгээр тушаалуудаар хэрэгжүүлэх арга хэмжээ тус бүрээр баталсныг 2021 оны А/346 дугаар тушаалаар өөрчлөлт оруулж Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд тоног төхөөрөмжөөр хангах зорилгоор нийт 59,809.2 мянган төгрөгийн үнэ бүхий 27 ширхэг зөөврийн компьютер бэлтгэсэн байна.	Засгийн Газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дүгээр заалтыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөх.	1	59,809.2					1	59,809.2		
Дүн					2	59,809.2					2	59,809.2		
Нийт дүн					5	847,524.3	1	427,672.7			2	59,809.2	2	360,042.4



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 08 дугаар сарын 08 № 150/ 2018-0044
АХТ-2021/11/НБ - СГХ - ТМБ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2021 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн А/78 дугаар, 2021 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн А221 дүгээр тушаалаар Ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээ тус бүрээр баталсныг сайдын 2021 оны А/346 дугаар тушаалаар өөрчлөлт оруулж, Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд тоног төхөөрөмжөөр хангах зорилгоор нийт 59,809,200.0 төгрөгийн үнэ бүхий 27 ширхэг зөөврийн компьютер бэлтгэсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглээний худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-ын Захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Цагаанхүү, нягтлан бодогч Т.Цогбадрах нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"БАЯН СУВАРГА АУДИТ"
ХХК-ИЙН АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
Г.ЮРА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3 Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

0010120396

\\10.10.10.20\Bichig_Khureg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-149.Docx

0010800538



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 151/401700/14

Улаанбаатар хот

801-2022/М/МН-004-ТН/5

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-ын 2021 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2,366,680,761.00 төгрөгийн 37 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.9-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийн дагуу мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, ил тод байршуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-ын Захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Цагаанхүү, нягтлан бодогч Т.Цогбадрах нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"БАЯН СУВАРГА АУДИТ"
ХХК-ИЙН АХЛАХ АУДИТОР

Ц НАРАНЧИМЭГ
Г ГҮНЖИДМАА
Г ЮРА

0010800536

[illegible]

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for writing. The lines are evenly spaced across the entire page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.